



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

АКТ

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IY байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.03.05 № 1/03 ЧАГ-САГ/2014/СТГА-ТШЗ

Төсвийн орлого болгох тухай

Баянзүрх дүүргийн Нийгмийн Халамж үйлчилгээний хэлтсийн Нөхөн олговрын сангийн 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:


Нөхөн олговрын сангаас иргэн Х.Чойжилсүрэн, Г.Даваажав, Ж.Золбоо нарт нөхөн олговрыг нэг сард 172,600 төгрөгөөр олгож 274,800 төгрөгийг илүү зарцуулсан нь Монгол Улсын Их Хурлын 2012 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 20 дугаар тогтоолын 20.1-д “Тэтгэвэр нь түр зогсоогдсон иргэдэд олгож байгаа нөхөн олговрын доод хэмжээг 2012 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн сард 140300 /Нэг зуун дөчин мянга гурван зуун/ төгрөгөөр, 2012 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 162,000 /Нэг зуун жаран хоёр мянган/ төгрөгөөр шинэчлэн тогтоосугай” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих”, Монгол улсын ерөнхий аудиторовын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.1 дэх хэсгийн заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Илүү олгосон 274,800 төгрөгийг Баянзүрх дүүргийн Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн дарга З.Үүрцайх, Сангийн мэргэжилтэн Г.Нансалмаа, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын мэргэжилтэн Э.Ганбат нараар нөхөн төлүүлэх улсын төсөвт төвлөрүүлж Төрийн сан дахь УАГ-ын 90000601 тоот дансанд 2014 оны 3 дугаар сарын 15-ны дотор төвлөрүүлэн, төсвийн орлого болгох
2. Тогтоосон хугацаанд төлбөрийг барагдуулж, биелэлтийг 2014 оны 4 дүгээр сарын 20-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Баянзүрх дүүргийн Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн дарга З.Үүрцайх, Сангийн мэргэжилтэн Г.Нансалмаа нарт хариуцуулав.

АКТЫГ

ЗӨВШӨӨРСӨН:



Г. Энхмаа

Баянзүрх дүүргийн нийгмийн халамж
үйлчилгээний хэлтсийн дарга



3.Үүрцайх

Г.Нансалмаа